



МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2020 оны 06 сарын 03 өдөр

Дугаар А - 192

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2 дахь заалт, Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.2, 10.3 дахь хэсгийг тус тус үндэслэн, банкны санхүүгийн байдлыг сайжруулж, банкны салбарын тогтвортой байдлыг хадгалах зорилгоор ТУШААХ нь:

1. "Монголбанкнаас банканд олгох зээлийн түр журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. "Монголбанкнаас банканд олгох зээлийн түр журам"-ыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал мөрдсүгэй.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (Н.Батсайхан), Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газар (А.Энхжин), Эрсдэлийн удирдлагын алба (Д.Баянзул)-д тус тус даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Б.ЛХАГВАСҮРЭН

12 1092

МОНГОЛБАНКНААС БАНКАНД ОЛГОХ ЗЭЭЛИЙН ТҮР ЖУРАМ

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү журмын зорилго шинэ **коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахал (цаашид “цар тахал” гэх)-ын үед** нийгэм, эдийн засагт үүссэн нөхцөл байдлыг харгалзан, нийтээр мөрдөж буй хорио цээрийн дэглэмийн үед банкны санхүүгийн байдлыг сайжруулж, банкны салбарын тогтвортой байдлыг хадгалах зорилгоор банканд Монголбанкнаас зээл олгох харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэ журмаар цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор банкинд зээл олгох зайлшгүй шаардлага, үндэслэл, шалгуур, нөхцөл, зээлийг буцаан төлүүлэх, хяналт тавихад баримтлах хэм хэмжээг зохицуулна.

Хоёр. ЗЭЭЛ ОЛГОХ ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА, ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ

- 2.1 Дараах нөхцөлүүдийн аль нэг хангагдсан тохиолдолд энэ журмын дагуу банканд зээл олгох зайлшгүй шаардлага үүссэн гэж үзнэ:
 - 2.1.1 Ковид-19 цар тахлын үед төрийн эрх бүхий этгээдээс тогтоосон хорио цээрийн дэглэмээс шалтгаалж банкны хэвийн үйл ажиллагаа алдагдаж, төлбөрийн чадварын үзүүлэлт буурах эрсдэл үүссэн;
 - 2.1.2 Ковид-19 цар тахалтай холбоотой нийтээр мөрдөгдөж буй хорио цээрийн дэглэм банканд зөрчигдөх эрсдэл үүссэн;
 - 2.1.3 Ковид-19 цар тахалтай тэмцэж буй эрүүл мэнд, онцгой байдлын байгууллагын төлбөр тооцоо банканд саатсан, эсвэл саатах эрсдэл үүссэн.
- 2.2 Зээл хүсэгч, зээлдэгч банк нь санхүүгийн байдлаа сайжруулахтай холбоотой дараах арга хэмжээ авах үүргийг хүлээнэ:
 - 2.2.1 Банкны бүтэц, орон тоог оновчтой болгох, үйл ажиллагааны зардлыг бууруулах;
 - 2.2.2 Активын бүтцийг сайжруулах, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх;
 - 2.2.3 Чанаргүй болон холбогдох этгээдийн активыг бууруулах;
 - 2.2.4 Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад арга хэмжээ.
- 2.3 Энэ журмын 2.2-т тусгасан үүргийн зээл олгохоос өмнө гүйцэтгэх, эсвэл зээл авсны дараа гүйцэтгэх байдлаар банктай тохиролцож болох бөгөөд гүйцэтгэлтэй уялдуулан зээлийг үе шаттай олгож болно.
- 2.4 Монголбанкнаас банканд олгох барьцаат зээлийн журам болон энэхүү журмын хүрээнд олгосон зээлийн өрийн үлдэгдэлтэй банканд зээл олгохгүй.
- 2.5 Зээлийг 90 хоног хүртэл хугацаатай олгож болох бөгөөд банкны хүсэлтийг үндэслэн 60 хоногоос дээшгүй хугацаагаар нэг удаа сунгаж болно.
- 2.6 Зээлийн хүү нь Монголбанкнаас банкинд олгох төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих барьцаат зээлийн хүү дээр 0.5 нэгж хувийг нэмсэнтэй тэнцүү

байна.

- 2.7 Зээлийн барьцаа, хямдруулалтын хувь хэмжээ нь Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан “Төв банкнаас банканд зээл, санхүүжилт олгоход барьцаалах хөрөнгө болон худалдан авах үнэт цаасны жагсаалт”-аар зохицуулагдана.
- 2.8 Энэ журмын 2.7-д заасан барьцааны зүйлийн шаардлагыг банк хангах боломжгүй тохиолдолд барьцаалуулагчийн өмчлөх эрх бүхий, гуравдагч этгээдийн аливаа шаардлагаас ангид (улсын бүртгэлийн эрх бүхий байгууллагын гэрчилгээ, тодорхойлолт, мэдээллээр баталгаажсан) үл хөдлөх хөрөнгийг 50-иас багагүй хувиар хямдруулан барьцаалж болно.
- 2.9 Банкнаас ирүүлсэн барьцаа хөрөнгө нь зээл, түүнтэй адилтгах тооцох актив бол уг активын төлбөрийн хуагцаан нь зээлийн төлөгдөх хугацаанаас хойш хамгийн багадаа 90 хоногийн дараа банканд эргэн төлөгдөхөөр байна.
- 2.10 Эрсдэлийн хямдруулалт тооцсоны дараах барьцаа хөрөнгийн үнэлгээ нь зээлийн нийт дүнгээс багагүй байна.
- 2.11 Барьцаа хөрөнгийн хүрэлцээ хангалтгүй бол банканд зээл олгохоос татгалзана.
- 2.12 Зээлдэгч банк зээлийн гэрээний хугацаанд дараах хязгаарлалтыг дагаж мөрдөх үүргийг хүлээх бөгөөд энэ талаар холбогдох гэрээнд тусгана:
 - 2.12.1 Нийт зээлийн өрийн үлдэгдэл, зээлтэй адилтган тооцох бусад актив, баталгаа, батлан даалт, бусад үүргийн үлдэгдлийг нэмэгдүүлэхгүй;
 - 2.12.2 Нийт харилцах, хадгаламж, бусад эх үүсвэрийг үлдэгдлийг нэмэгдүүлэхгүй;
 - 2.12.3 Ногдол ашиг хуваарьлахыг хориглоно;
 - 2.12.4 Холбогдох этгээдийн болон банкны эрх бүхий албан тушаалтны эх үүсвэрээс зарлага гаргах, түүнд хүү хуримтлуулахыг хориглоно;
 - 2.12.5 Холбогдох этгээдтэй Банкны үйл ажиллагаанд хийх хязгаарлалтыг тооцох, хангах, тайлагнах, хяналт тавих журмын 3.4, 3.5.2-3.5.5 дахь хэсэгт тусгасан хэлцэл хийхийг хориглоно;
 - 2.12.6 Банкны эрх бүхий албан тушаалтанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалин олгож, урамшуулал, хандив, дэмжлэг олгохыг хориглоно;
 - 2.12.7 Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар тусгайлан тогтоосон бусад хязгаарлалт.
- 2.13 Зах зээлийн үйл ажиллагаа хариуцсан газар энэ журамд заасан үүргийг гүйцэтгэхийг зөвшөөрч зээл хүссэн банкинд дараах баримт бичгийг энэ журмын 1 дүгээр хавсралтын дагуу бүрдүүлж хүлээн авсны үндсэн дээр зээл олгох эсэхийг судална:
 - 2.13.1 Зээл хүссэн албан бичиг;
 - 2.13.2 Барьцаа хөрөнгөд санал болгож байгаа активын жагсаалт,
 - 2.13.3 Ирэх 6 сарын хугацааны мөнгөн хөрөнгийн орох гарах урсгалыг таамаглал,
 - 2.13.4 Зээл авснаар банкны санхүүгийн байдал хэрхэн сайжрах талаар танилцуулга,

2.13.5 Энэ журам, гэрээнд заасны дагуу барьцаа хөрөнгийг зээлдүүлэгчийн өмчлөлд үл маргах журмаар шилжүүлэх эрх бүхий этгээдийн шийдвэр.

2.14 Зээлдэгч банк зээлийн хугацааг сунгуулах хүсэлтийг зээлийн хугацаа дуусахаас ажлын 10 хоногийн өмнө энэхүү журмын 2.13.3-д заасан баримт бичгийн хамт Монголбанканд ирүүлнэ.

2.15 Монголбанк зээл олгох болон сунгах шийдвэр гаргахад шаардлагатай гэж үзсэн нэмэлт мэдээллийг банкнаас шаардаж болно.

Гурав. ЗЭЭЛ ОЛГОХ

3.1 Банкнаас ирүүлсэн хүсэлтийг Зах зээлийн үйл ажиллагаа хариуцсан газар хүлээн авч судална.

3.2 Хяналт шалгалтын асуудал, үйл ажиллагаа хариуцсан газар барьцаа хөрөнгийг шалгах, энэ журмын 2.2 дахь заалтад шаардлага, түүний биелэлтийг хангуулах санал боловсруулна.

3.3 Барьцаа хөрөнгийн хямдруулалтын хувь, үнэлгээг Эрсдэлийн удирдлага хариуцсан нэгж гаргана.

3.4 Хяналт шалгалтын асуудал, үйл ажиллагаа хариуцсан газар банкны хүсэлт, банкны санхүүгийн байдлыг сайжруулах шаардлага, хэрэгжүүлэх хугацаа, зээлийг хэсэгчлэн олгох эсэх, үйл ажиллагаанд мөрдүүлэх хязгаарлалтын саналаа Банкны хяналт шалгалтын хороо (цаашид “хороо” гэх)-нд хүргүүлж, хороо нь ажлын 3 өдрийн дотор зөвлөмж гаргана.

3.5 Монголбанкны Ерөнхийлөгч нь хорооны зөвлөмжийг харгалзан банканд зээл олгох асуудлыг эцэслэн шийдвэрлэж, энэхүү журмын 2 дугаар хавсралтад тусгасан маягтын дагуу шийдвэрийг баталгаажуулна.

3.6 Банкны барьцаа хөрөнгийг зээл эргэн төлөгдөх өдөр хүртэл тусгаарлах ажлыг Монголбанкны тайлан бүртгэл, хяналт шалгалт болон зах зээлийн үйл ажиллагаа хариуцсан газрууд хамтран гүйцэтгэнэ.

3.7 Монголбанк банканд зээл олгохдоо зээлдэгч банктай энэхүү журмын 3 дугаар хавсралтын дагуу Зээлийн гэрээ болон Барьцааны гэрээ байгуулна. Энэ арга хэмжээг Зах зээлийн үйл ажиллагаа хариуцсан газар хэрэгжүүлнэ.

3.8 Хяналт шалгалтын асуудал, үйл ажиллагаа хариуцсан газар банкны санхүүгийн байдал сайжруулах шаардлага, үйл ажиллагааны хязгаарлалтын биелэлтэд хяналт тавих бөгөөд хэрэгжилт хангалтгүй гэж үзвэл Зах зээлийн үйл ажиллагаа хариуцсан газарт мэдэгдэж зээл олголтыг зогсоох арга хэмжээ авна.

Дөрөв. ЗЭЭЛ ХҮССЭН БАНКАНД ТАВИХ ШААРДЛАГА

4.1 Монголбанк энэ журмын хавсралтад заасан гэрээний дагуу дор дурдсан үүргийг хууль, гэрээний дагуу хүлээхийг зөвшөөрсөн банктай байгуулна:

4.1.1. Зээлдэгч банк нь Монголбанканд барьцаа болгосон активыг бүхэлд нь зээлийн хугацаанд гуравдагч этгээдэд аливаа хэлбэрээр шилжүүлэхгүй, шаардах эрх

үүсгэхгүй, эрхийн зөрчилгүй, аливаа доголдолоос ангид байлгах;

- 4.1.2. Зээлийн гэрээ байгуулагдснаас хойш барьцааг хууль тогтоомж, холбогдох журмын дагуу үүссэнийг гэрчилсэн, баталгаажуулсныг нотлох шийдвэр (банкны эрх бүхий этгээдийн шийдвэр), баримт бичгийн хамт ажлын 2 өдрийн дотор Монголбанканд ирүүлэх;
 - 4.1.3. Зээлдэгч банк зээлийн хугацаанд 2 долоо хоног тутам олгосон зээлийн өрийн үлдэгдэл, зээлийн ангилалын мэдээг энэхүү журмын 4 дүгээр хавсралтын дагуу бэлтгэж, 2 долоо хоног дууссанаас хойш дараагийн долоо хоногийн эхний ажлын өдөрт багтаан Монголбанканд албан бичгээр ирүүлэх;
 - 4.1.4. Зээлийн барьцаанд ирүүлсэн актив нь хугацаанаасаа өмнө эргэн төлөгдсөн, зээлийн ангилал буурсан тохиолдолд зээлдэгч банк нэн даруй Монголбанканд мэдэгдэх;
 - 4.1.5. Барьцаа хөрөнгийн дахин үнэлгээ нь эрсдэлийн хямдруулалт тооцсоноор зээлийн дүнгээс буурсан тохиолдолд, зээлдэгч банк ажлын 3 өдрийн дотор барьцаа хөрөнгийн хэмжээг анхны барьцаа хөрөнгийн үнэлгээний хэмжээнд хүргэж нэмэгдүүлэх;
- 4.2 Шаардлагатай тохиолдолд Монголбанкны эрсдэлийн удирдлага хариуцсан нэгж, зах зээлийн үйл ажиллагаа хариуцсан газар хамтран банкны нийт барьцаа хөрөнгийг дахин үнэлнэ.

Тав. ЗЭЭЛИЙГ БУЦААН ТӨЛҮҮЛЭХ

- 5.1 Зээлдэгч банк энэхүү журам, санхүүгийн байдлыг сайжруулах шаардлага, үйл ажиллагааны хязгаарлалт, гэрээний заалтыг биелүүлээгүй тохиолдолд Монголбанк зээлийн гэрээг хугацаанаас нь өмнө нэг талын санаачилгаар дангаар цуцалж, зээлийг төлүүлэх арга хэмжээ авна.
- 5.2 Зээл бүрэн төлөгдөж дуусахад барьцааны эрхийг дуусгавар болгосон тухай банканд мэдэгдэж, зохих арга хэмжээг авна.
- 5.3 Зээл буцаан төлөгдөх өдөр зээлдэгч банк Монголбанкин дахь харилцах дансандаа зээлийн төлбөрийг төлөхөд хүрэлцэхүйц хэмжээний мөнгөн хөрөнгөтэй эсэхээс үл хамааран суутган төлүүлэх бөгөөд үлдэгдэлд зээлийн үндсэн хүүгийн 20 хувьтай тэнцүү нэмэгдүүлсэн хүү тооцно.
- 5.4 Зээлийн төлбөрийн хугацаанаас хойш 3 хоногт зээлийн үлдэгдэл төлөгдөөгүй бол Зах зээлийн үйл ажиллагаа хариуцсан газар барьцаа хөрөнгөөр төлбөрийг хангуулах санал Монголбанкны Ерөнхийлөгчид танилцуулж шийдвэрлүүлнэ.
- 5.5 Хяналт шалгалтын асуудал, үйл ажиллагаа хариуцсан газар зээлээ төлөөгүй банканд авах арга хэмжээний саналыг Монголбанкны Ерөнхийлөгчид танилцуулж шийдвэрлүүлнэ.

Зургаа. ХЯНАЛТ

- 6.1 Монголбанкны зах зээл болон хяналт шалгалтын үйл ажиллагаа хариуцсан газрууд зээл авсан банканд тогтмол хяналт тавьж ажиллана.

- 6.2 Барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэлгээнд эрсдэлийн удирдлага хариуцсан нэгж хяналт тавьж, хөрөнгийн үнэлгээ өөрчлөгдсөн тохиолдолд зах зээлийн үйл ажиллагаа хариуцсан газарт мэдэгдэнэ.
- 6.3 Монголбанкнаас олгосон зээл хугацаандаа төлөгдөөгүйгээс хугацаа хэтэрсэн, эсхүл чанаргүй активт шилжсэн тохиолдолд Монголбанкны активыг ангилах, болзошгүй алдагдлын нөөцийн сан байгуулах, зарцуулах журмын дагуу ангилж, нөөцийн сан байгуулна.
- 6.4 Монголбанкнаас олгосон зээлийг Монголбанкны нягтлан бодох бүртгэлийн журмын дагуу бүртгэж, бүртгэлээр тавих хяналтыг Монголбанкны тайлан бүртгэл хариуцсан газар гүйцэтгэнэ.
- 6.5 Зээлийн хугацаанд барьцаа хөрөнгийг жагсаалтад заагаагүй хөрөнгөөр солих, чанарыг бууруулах, хэлцлийн төрлийг өөрчлөх санал, аливаа шийдвэр гаргахгүй.
- 6.6 Энэхүү журмыг зөрчсөн Монголбанкны ажилтан, албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

МОНГОЛБАНК